

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН
/Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/

2022.10.21

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан нөхцөл тайлбар)
				Он	Түвшин	
ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
Боловсрол						
2.3. Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна.						
1	Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургууль, цэцэрлэгийн барилгыг ашиглалтанд оруулна.	1,550.0	Шивээговь сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэл 35 хувь Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэг барилга гүйцэтгэл 50 хувь	2021	50	2021 онд барилгын гадна цахилгаан, гадна бохирын шугамын ажил хийгдсэн. 2022 онд барилга угсралтын суурийн ажил хийгдэж, 1-р давхарын төмөр бетон каркас цутгалтын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Ажлын явц 35%-тай байна. Барилгын ажлыг эрчимжүүлэх, гэрээт хугацаанд гүйцэтгэх, ажлын талбайд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах талаар байгууллагын даргын 2022 оны 01/269,01/289 тоо албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлэн, захиалагчийн хяналтыг 100% хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт 90 хувь
2	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгуудыг өргөтгөж, шинээр барина.	800.0	Ашиглалтанд орох сургуулийн тоо -1 Цэцэрлэгийн тоо-2	2021	50	1.Сүмбэр сумын 640 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажил 2022.10.13-ны өдөр улсын комисс ажиллаж, тодорхой үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулсан.Ажлын гүйцэтгэл 100% хийгдсэн. 2.Шивээговь сумын 150 хүүхдийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр “Монночи Кон Трейд” ХХК шалгарч барилгын суурийн ажил хийгдэж, 1-р давхарын төмөр бетон каркас цутгалтын ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 45 хувьтай. Шаардлагатай үүрэг даалгавар, зөвөлгөө зөвлөмжийг өгч, захиалагчийн хяналтыг 100% хэрэгжүүлэн ажиллаж байна. 3.Сүмбэр сумын 5-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг БШУЯ-ны захиалгатай, Азийн хөгжлийн банкны 1,5 тэр бум төгрөгийн санхүүжилтээр “Веритас Глобал”ХХК гүйцэтгэж, 90 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгээд байна. 4. Сүмбэр сумын 5-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг АЗДТГ-ын захиалгатай, Улсын төсвийн 1,5 тэр бум төгрөгийн санхүүжилтээр “Түмэн-Алт”ХХК гүйцэтгэж, 80 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгээд байна. Хэрэгжилт 90 хувь
		296.5				
		35.0				
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал						
2.5. Хүн амын хөгжлийг хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулна.						
3	Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулж, шинээр баригдаж байгаа зам, талбай, барилга, байгууламжид саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.	-	Дэд бүтцийг тусгасан шинэ барилгын тоо-2 Дэд бүтцээ сайжруулсан байгууллагын тоо-2	2021	70	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга угсралтын ажлуудад үндсэн хийц бүтээцэд барилга захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээс гадна зураг төсөл, тоо хэмжээнд тусгагдсаны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц гарц дэд бүтцийн асуудлыг холбогдох норм дүрэм, стандарт шаардлагын дагуу гүйцэтгүүлэхээр шаардлага тавин ажиллаж, аймгийн нэгдсэн эмнэлэг, 640 хүүхдийн суруулийн барилгад зураг төслийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц гарцыг гүйцэтгэж ашиглалтад оруулаад байна.

						<p>2. Мөн төр хувийн хэвшлийн 15 байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэний орц, гарцын асуудлыг бодит байдалтай уялдуулан шийдвэрлэж байгаа талаарх олон улсын жишээ болон холбогдох стандартыг хураангуйлсныг хүргүүлж, биелэлтийг хангаж хариу ирүүлэх талаар Газрын даргын 2022.06.03-ны өдрийн 01/176 хугацаатай албан бичгийг хүргүүлсний дагуу 8 байгууллагаас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ажлын тайланг ирүүлээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийтийн номын сангийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх буланг байгуулж, компьютер, чихэвч, томруулдаг шил, 109 ширхэг сонсдог аудио ном, CD тоглуулагч, дтэт сонсдог готын төхөөрөмжүүдийг байгшуулсан байна. - Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар дохионы хэлний тайлбарт дүрс, харааны шил, ариун цэврийн өрөөний бариул байршуулсан ба гадна хаалганы довжоог тэргэнцэр орох боломжоор хангасан байна. Мөн хөрөнгө санхүү шаардлагатай байгаа ажилд холбогдох байгууллагуудад саналыг хүргүүлсэн байна. - Биеийн тамир спортын газар ариун цэврийн хоёр өрөөнд стандартын дагуу бариул байршуулж, орох гарах гарцанд тэргэнцэртэй хүн үйлчлүүлэх налуу замыг хийсэн байна. - Авто тээврийн төв засварын ажилд хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэх нөхцөл шаардлагыг тусгасан байна. - Баянтал сумын 4-р сургууль байгууллагадаа 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэнг ажиллуулдаг бөгөөд гадна талд тэргэнцэртэй хүн орох гарах гарцын налуу замыг засварласан байна. - Татварын хэлтэс барилгад засварын ажлыг төлөвлөж байгаа бөгөөд төлөвлөлтөд гадна талд тэргэнцэртэй хүн орох гарах гарцын налуу замыг стандартын дагуу болгох ажлыг тусгаад байна. - Боржигон чуулга хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхцөл шаарлагыг хангасан ариун цэврийн өрөө, гадна пандус зэргийг 2021-2023 онд шинээр баригдаж буй барилгын төлөвлөлтөд оруулаад байна. <p style="text-align: right;">Хэрэгжилт 100 хувь</p>
4	"Ахмадын өргөө"-ний барилгыг шинээр барьж, ахмад настны хөгжлийн төвийг байгуулан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	-	Шаардагдах хөрөнгийг шийдвэрлэнэ.	2021	30	<p>Зураг төслийн гүйцэтгэгчээр "Аслаан" ХХК шалгарч зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэн захиалагчид хүлээлгэн өгсөн. Байгууллагын зүгээс зураг төсөл хянахад хамтран ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100 хувь</p>
Үндэсний бахархал, өв соёл						
2.6. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.						
5	Дуу бүжгийн Боржигон чуулгын шинэ барилгыг барина.	2,317.7	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40 хувь	2021	10	<p>Боржигон чуулгын барилга угсралтын ажил суурь, цутгамал төмөр бетон каркасын ажил бүрэн дуусч, барилгын гадна ханын өрлөгийн ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 70%-тай. Манай байгууллагын зүгээс захиалагчийн техник хяналтыг 100% хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 90 хувь</p>
6	Төрийн байгууллагын албан хаагчдыг хуучин Монгол бичгээр унших, бичих	4.2	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо-7	2021	Албан хаагчдыг	<p>Монгол бичгийг сурталчлах, хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс байгууллагын хэмжээнд төлөвлөгөө боловсруулан ажилласнаас</p>

	<p>чадавхыг сайжруулах сургалт, арга хэмжээг зохион байгууна.</p>		<p>Нийт төрийн албан хаагчдын 70 хувийг сургалтад хамруулна.</p>		<p>бүрэн хамруулах</p>	<p>гадна холбогдох дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Аймаг орон нутгаас зохион байгуулсан олимпиад тэмцээн уралдаанд байгууллага хамт олноороо 2 удаа оролцсон - Хүмүн бичиг сонинг бүтэн жилээр 2 жилийн турш захиалж албан хаагчдаар судлуулж байна - Монгол бичгийн самбар байгуулж мэдээ мэдээллийг монгол бичгээр бичүүлж байршуулж байна - Албан хаагчдын түвшинг тогтоосон - Эрхэмлэх 9 зүйл болон Төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагийг Монгол бичгээр бичиж байгууллагад байршуулсан - Албан хаагчдын мэдээллийг монгол бичгээр гарган байрлуулсан - “Mongolian script” чат нээн багш Э.Олонцэцэгээс даалгавар авч гйцэтгэн ажилладаг - Дотор гадна хаягуудыг монгол бичгээр бичиж байршуулсан - Албан хаагчдын компьютерт монгол бичгийн фонд суулгасан - Албан хэрэг хөтлөлтийг монгол бичгээр хөтлөхөд анхаарч 50 ширхэг хэвлэмэл хуудас буюу бланкийн загварыг гаргаж Архивын ерөнхий газар захиалга өгсөн зэрэг ажлуудыг санаачлан зохион байгуулж байна. <p>Үүний үр дүнд албан хаагчдын мэдлэг дээшилж, хэрэглэх сонирхолтой болж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжилт 100%</p>
<p>7</p>	<p>Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллана.</p>	<p>-</p>	<p>Гэрээ байгуулан хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо -5-аас доошгүй</p>	<p>2021</p>		<p>Байгууллагын цахим хуудсанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас цахим өргөдөл хүсэлт авах цонхыг шинэчлэн оруулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын вэб сайтанд холбож, олон нийтэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх тал дээр анхаарч ажиллаж байна. Байгууллагын сайтад доор мэдээллүүдийг байршуулан ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Онцлох мэдээ цэсэнд-42 мэдээлэл • Хууль цэсэнд-7 хууль, журам • Төлөвлөгөө цэсэнд-9 мэдээлэл • Газрын удирдлагын хэлтэс цэсэнд-24 мэдээлэл • Ил тод байдал цэсэнд-74 мэдээлэл • Сургалт цэсэнд-6 мэдээлэл • Цахим гарын авлага цэсэнд-5 төрлийн гарын авлагуудыг тус тус байршуулан ажилласан байна. <p>Байгууллагын пэйж хуудаст-83 мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэсэн байна.</p>

						Хэрэгжилт 100 хувь
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр						
3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангах хувь хэмжээг нэмэгдүүлэх, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.						
8	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.	450.0	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл- 85	2021	30	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажил 2,1 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр хийгдэж байгаа бөгөөд 2022 онд суурь, төмөр бетон каркас цутгалт, цонхны ажил бүрэн хийгдэж, гадна ханын өрлөг, дээврийн ажил хийгдэж, дотор заслын ажил хийгдэж байна.2022 онд ажлын гүйцэтгэлийг 100% гүйцэтгэн, ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Хэрэгжилт 90 хувь
Эрчим хүч						
3.5. Эрчим хүчний найдвартай байдлыг хангана.						
9	Шинээр өмчлөлд олгосон газруудад цахилгаан татна.	239.2	Тэрэгтийн гэр хороололд цахилгаан татах ажлын гүйцэтгэл-100 Шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэх ажлын гүйцэтгэл, хувь-100 Баянтал сумын Лүн гэр хорооллын ай өрхийн цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэх ажлын гүйцэтгэл-100	2021	70	Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Тэрэгтийн суурьшлын бүсийн айл өрхүүдийг цахилгаанд холбохоор 239,2 сая төгрөг тусгагдсан бөгөөд ажлын гүйцэтгэгчээр “Жи пауэр” ХХК шалгарч ажлыг 100% хийж гүйцэтгэн, байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллуулах шатандаа байна. - Сүмбэр сумын ОНХС-н хөрөнгө оруулалтаар Бурхант суурьшлын бүсийн цахилгаан хангамжын ажлыг 141,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Нуклон”ХХК гүйцэтгэж, байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллуулах шатандаа байна. Хэрэгжилт 100 хувь
		241.0				
		116.95				
		100.0				
Тээвэр, логистик						
3.6. Аймаг, сумдын төвийн авто замын сүлжээг нэмэгдүүлж, тээвэр, логистикийн төв байгуулна.						
10	Аймаг, сумдын төвд явган хүний зам, дугуйн зам барина.	-	Шинээр тавих явган замын урт, км-1	2021	30	Сүмбэр сумын 2-р багийн Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил АЗДТГ захиалгатай “Хүслэн хийморь” ХХК хийж гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Тус тохижилтын ажилд хэсэгчилэн хийгдсэн 16 ширхэг гэрэлтүүлэг, 2900м2 явган зам, резин хавтан 254м2, бетон талбай 151 м2, дугуйн зам 1050м2 тус тус хийгдсэн. Хэрэгжилт 100 хувь
Барилга, хот байгуулалт						
3.7. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын салбарыг орон нутагт хөгжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.						
11	Сүмбэр сумын төвд дахин төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.	-	Зураг төсөв хийгдэж, бэлтгэл ажлыг хангана.		70	Сүмбэр сумын 1 дүгээр багт дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлэхээр Багш нарын байрны оршин суугчидтай 2021.03.11-ний өдөр уулзалтыг зохион байгуулж, иргэдээс хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Нийт 28 айл өрхөөс 11 өрх дахин төлөвлөлтөд оруулахыг дэмжсэн хүсэлт ирүүлээд байна.Зураг төслийн “Жаргалант хийц” ХХК-тай 2021 онд Сүмбэр сумын 1,2 багийн нутаг дэвсгэрт байрлах нийтийн эзэмшлийн болон дан байрнуудын дахин төлөвлөлтөд хамруулах зураг төслийн ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан зураг төсөл судалгааны ажлын гүйцэтгэл 95 хувьтай захиалагчаар батлуулахад бэлэн болсон байна. Хэрэгжилт 90 хувь

12	Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж, бетон зуурмаг, вакум цонх, бетон эдлэл зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ.	-	Зээл, төсөл хөтөлбөрт хамруулах, борлуулалтыг дэмжиж ажиллана.		70	Аймгийн хэмжээнд барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж буй 5 иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг авч мэдээллийн санд бүртгэсэн.Үүнд: 1. "Илчит сансар" ХХК ф1000-н кольцо 200ш, ф1500-н кольцо 160ш, ф700-н кольцо 100ш, L4-н лотки 30ш, L2-н 80ш, ф1500 ташуу таг 100ш, ф1000-н ташуу таг 120ш 2. "Эрин зууны холбоос" ХХК дулаан блок 5000ш, нүхтэй блок 10000ш 3. Сүмбэр сумын иргэн Н.Ганхуяг бетон евро хашаа 1300м 4. Сүмбэр сумын иргэн Э.Амарсайхан бетон үйлдвэрлэлийн зуурмаг 850м3 5. "Алтан булаг уул" ХХК 2500м3 бетон зуурмаг зэрэг бүтээгдэхүүнийг тус тус үйлдвэрлэсэн байна. Бетон зуурмаг болон блок үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа "Алтан булаг уул" ХХК, "Эрин зууны холбоос" ХХК зэрэгт холбогдож үйлдвэрлэлийн зөвшөөрөл авах талаар зөвлөгөө өгч, холбогдох мэдээллийг ирүүлэхийг мэдэгдсэний дагуу "Эрин зууны холбоос" ХХК үйлдвэрлэлийн тохирлын гэрчилгээг авсан байна. Хэрэгжилт 100 хувь
13	540 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	-	Сүмбэр сумын 3 дугаар багт 315 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. Сүмбэр сумын Найрамдал хотхонд 40 айлын орон сууцны барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70 хувь	2021	30	Сүмбэр сум 3-р багт 315 айлын орон сууц бариулахаар орон нутгаас газрын асуудлыг бодлогоор дэмжиж шийдвэрлэсэн. Сүндэр хотхон барилгын ажлыг гүйцэтгэхээр "Юникел тауэр" ХХК шалгарч ажлаа эхлүүлээд байгаа бөгөөд 2023 оны 2-р улиралд багтаан 126 айлын орон сууцыг ашиглалтад өгөхөөр төлөвлөгөөтэй ажиллаж байна. Мөн Сүмбэр сумын Найрамдал хотхонд 36 айлын орон сууцны барилгын ажлыг орон нутгийн "Осо констаркшн"ХХК 1,2 дугаар давхарын цутгамал төмөр бетон каркас ажлыг гүйцэтгэж байна. Байгууллагын зүгээс шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, ажлын явцад үе шатны ажилд зөвлөгөө зөвлөмж өгч хамтран ажиллаж байна. Байгууллагын зүгээс шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, ажлын явцад үе шатны ажилд зөвлөгөө зөвлөмж өгч хамтран ажиллаж байна. Хэрэгжилт 70 хувь
14	Айл өрхийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбож, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.	-	Шинээр сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон өрхийн тоо - 20	2021	70	Сүмбэр сумын 3-р багт авто зам дагуу байрлах үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудад нүхэн жорлонг стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар шинэчлэн солих хугацаатай албан шаардлагыг2022.06.03-ны өдрийн 01/178 албан тоотоор 3 аж ахуйн нэгжид биелэлтийг III улиралд ирүүлэхээр хүргүүлсэн.Мөн орон нутгийн "Илчит-Сансар"ХХК сайжруулсан жорлонгийн кольцоог үйлдвэрлэж нийт 39 айл өрхөд нийлүүлэлт хийсэн байна. Хэрэгжилт 90 хувь
ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО						
"Цахим Монгол"-төрийн шуурхай үйлчилгээ						
4.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг ханган, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.						
15	E-mongolia системийг сурталчилж, иргэдэд, мэдээ мэдээллийг хүргэнэ.	-	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо-2	2021	70	Газартай холбоотой 11 төрлийн лавлагааг E-mongolia цахим системийг ашиглан авах боломжтой болсон. Үүнд: • Газар эзэмших эрхийн гэрчилгээний лавлагаа; • Газар эзэмших эрхийн лавлагаа; • Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа;

						<ul style="list-style-type: none"> • Газрын кадастрын нэгж талбарын тодорхойлолт; • Газрын төлбөр, тооцоо нийлсэн акт; • Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээний лавлагаа; • Кадастрын зураг хэвлэж авах; • Нэгж талбарын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа; • Нэгж талбарын үнэлгээний лавлагаа; • Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газар эзэмших, ашиглах, өмчлөх саналаа өгөх; • Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зураг, тайлан харах <p>Үр нөлөө: Газартай холбоотой 11 төрлийн лавлагаа үйлчилгээ E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэмэгдсэнээр иргэн, хуулийн этгээд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хаанаас ч өөрийн эзэмшил газрын лавлагаа үйлчилгээг E-mongolia авах боломжтой юм.</p> <p>-Салбарын хэмжээнд барилга байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн баримт бичгийн бүрдэл авах, барилга байгууламжийг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэх, инженерийн шугам сүлжээний зурган мэдээллээр үйлчлэх зэрэг иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/-д нэвтрүүлээд байна.</p> <p>-Мөн барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар, зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах үйл ажиллагааг urban.gov.mn цахим системээр олгохоор үйл ажиллагааг нэвтрүүлээд байна.</p> <p>Мөн иргэд, олон нийтэд e-mongolia төрийн цахим системээс газартай холбоотой лавлагааг хэрхэн авах талаар сумдад зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгөөр нийт арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>
16	Төрийн байгууллагуудад дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлж, ашиглалтыг дээшлүүлнэ.	-	ERP систем нэвтрүүлсэн байгууллагын тоо – 40	2021	30	<p>ERP системийг нэвтрүүлэх талаар судалж, Цахим хөгжлийн яамнаас 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан цахим сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулсан. Үүний дагуу ERP mongolia цахим системийн хүний нөөцийн удирдлага цэсний албан тушаал хэсэгт нийт 16 албан тушаалын мэдээллийг оруулж, төрийн албан хаагч хэсэгт 13 албан хаагчийн мэдээллийг, А, Б анкет, холбоо барих мэдээллийн хамт оруулсан. . Мөн байгууллагад ирсэн бичгийг хүлээн авах болон Говьсүмбэр аймгийн Төрийн байгууллагуудад албан бичгийг ер mongolia цахим системээр дамжуулан хүргэж байна. Манай байгууллага нь БХБЯ-аас салбарын хэмжээнд нэгдсэн системээр албан хэрэг хөтлөлтийг ABLE программ ашиглан 2017 оноос эхлэн ашиглаж хэвшсэн бөгөөд ERP системийн хэрэглээг нэвтрүүлэх чиглэл өгч байгаа талаар ГЗБГЗЗГ-т саналаа танилцуулсан. ABLE программ болон газрын цахим системүүдээр дамжуулан цахим архивыг үүсгэсэн.</p> <p>Хэрэгжилт 90 хувь</p>
17	“Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	50.0	Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100	2021	90	<p>Иргэдийг мэдээ мэдээллээр хангах ажлын хүрээнд Үйл ажиллагааны мэдээллийг байгууллагын цахим хуудас олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дараах байдлаар мэдээллэсэн байна.</p> <p>1.Байгууллагын үйл ажиллагааны сарын мэдээг сар бүр гарган байгууллагын цахим сайтад байршуулан ажиллаж байна.</p>

2.Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ээр дамжуулан дуудлага худалдааг тогтмол цахимаар ил тодоор зохион байгуулан ажиллаж байна.

3.Газрын удирдлагын хэлтэс 6 төрлийн цэст 23 мэдээлэл байршуулсан.

4.Байгууллагын цахим сайт, фэйсбүүк хуудас, фэйж хуудсанд тогтмол байршуулж энэ сарын байдлаар 5439 иргэн хандалт өгч, 56 иргэн өөрийн фэйсбүүк цахим хаягтаа хуваалцсан байна.

5.Байгууллагын цахим сайтад 7 төрлийн цахим гарын авлагыг байршуулж, татаж авах боломжийг бүрдүүлэн иргэд, олон нийтэд нээлттэйгээр үйлчилж байна.

6.Сүмбэр суманд 2022 оны 04 дүгээр сарын 18, 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрүүдэд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж иргэдэд “Газрын харилцаа-цахим шилжилт”-ийн талаар нийт 173 иргэд, олон нийтэд мэдээ мэдээлэл өгч ажилласан.

7.Баянтал суманд 2022 оны 04 дүгээр сарын 19, 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрүүдэд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж иргэдэд “Газрын харилцаа-цахим шилжилт”-ийн талаарх мэдээ мэдээллийг өгч нийт 71 иргэдийг мэдээ, мэдээллээр ханган үйлчилсэн.

8. Шивээговь суманд 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрүүдэд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж иргэдэд “Газрын харилцаа-цахим шилжилт”-ийн талаарх мэдээ мэдээллийг өгч нийт 32 иргэдийг мэдээ, мэдээллээр ханган үйлчилсэн.





Байгууллагын govisumber.gazar.gov.mn цахим сайтын ил тод, төсөв санхүү цэсэд Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 9, Батлагдсан төсөв 3, Санхүүгийн аудитын тайлан 3, Санхүүгийн тайлан 8, Төсвийн төсөл 2, шагнал, тэтгэмж урамшуулал 3 болон санхүүгийн ил тодын самбарт дээрх мэдээллүүдийг тус тус байршуулан ажилласан.

Хэрэгжилт 100 хувь

18	Тусгай зөвшөөрөл, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэнэ.	-	Цахимаар хүлээн авч, шийдвэрлэж байгаа тусгай зөвшөөрлийн тоо - 4 Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байгаа байгууллагын тоо – 24 Цахим болон нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь -100	2021	70	2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн улсын хэмжээнд газартай холбоотой өргөдлийг газрын цахим сайт болох www.egazag.gov.mn сайтны тусламжтайгаар цахимаар авч эхэлсэн бөгөөд аймгийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар нийт 474 иргэн, хуулийн этгээдээс газартай холбоотой цахим өргөдөл ирүүлснээс шаардлага хангаагүй цуцалсан 95 өргөдөл, цахим 379 өргөдөл үүссэнийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Цахим өргөдлийн шийдвэрлэлт 100 хувьтай байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Сүмбэр суманд-299 • Баянтал суманд-36 • Шивээговь суманд-44 Мөн байгууллагын цахим хуудсанд өргөдөл, санал хүсэлт илгээх цэс нэмж ажилласан. Хэрэгжилт 100 хувь
Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба						
4.2. Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлнэ.						
19	Аймгийн Цагдаагийн хэлтсийн барилгыг ашиглалтад хүлээн авч эрүүлжүүлэх байрны засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.	1323.8 36.5	Барилгын ажлын гүйцэтгэл – 100 хувь Засварын ажлын гүйцэтгэл- 100 хувь	2021	70	Аймгийн Цагдаагийн хэлтсийн барилга байгууламжид 2022.05.02-ний өдөр улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан. Хэрэгжилт 100 хувь
20	Төрийн албыг мэргэшсэн, тогтвортой үйл ажиллагаа явуулах, албаны залгамж чанарыг хангах, төрийн албан хаагчдын манлайлал мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх төрийн албанд шатлан дэвших нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	30.0	Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн-10-аас доошгүй Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо- 800-аас доошгүй Зохион байгуулах шалгалтын тоо-2-оос доошгүй Гүйцэтгэлийн ерөнхий дүн өмнөх жилээс 1-ээс доошгүй хувиар сайжирсан байна Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь -100	2021	90	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг Газрын даргын 2022 оны А/02 тоот тушаалаар шинэчлэн гаргаж, хөтөлбөрийг хангах төлөвлөгөөг 2022.02.01-ний өдөр батлан хэрэгжилтийг ханган ажилласан. 2022 оны хагас жилийн байдлаар байгууллагын албан хаагчид нийт 18 сургалт, семинарт цахим болон танхимаар хамрагдсан байна. 2022 онд төрийн албан хаагчийн чиглүүлэх богино хугацааны сургалтад 7 албан хаагч 11 удаагийн сургалтад, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдсан байна. Мөн байгууллагын даргын А/05 тушаалаар баталсан Сургалтын төлөвлөгөөний дагуу байгууллагын дотоод сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг 2021 оны үйл ажиллагаагаар салбарын хэмжээнд шилдэг мэргэжилтэн, газрын даамал, шилдэг байгууллагын хийж хэрэгжүүлсэн ажлаас туршлага судалж танилцуулах сэдвийн хүрээнд орсон бөгөөд албан хаагчид тал талын мэдлэг олж авахаас гадна, илтгэх ур чадвараа дээшлүүлж, бусаддаа зааж зөвлөж, үлгэр дуурайлал авсан үр дүнтэй сургалтууд болсон. Хэрэгжилт 90 хувь
21	Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Иргэдэд зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо-5 Хамрагдсан иргэдийн тоо- 200 Төрийн албан хаагчдад			Авлигатай тэмцэх газраас явуулж байгаа видео бичлэг, танилцуулгаас 2022 онд нийт 8 мэдээллийг байгууллагын фэйсбүүк пэйж “Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар” хуудсаар орон нутгийн Чойр зар, Говьсүмбэр гэсэн цахим зарын фэйсбүүк хаягаар иргэд, олон нийтэд түгээсэн. 2021.02.30-ны өдөр “Шударга ёс хөгжил дэвшил”-д 110 мэдээллийн самбарын мэдээ мэдээллийг шинэчилсэн. Мэдээллийн самбарт албан хаагчдын утас, байгууллагын ёс зүйн дүрэм, ТАХ-н эрхэмлэх есөн зүйл,

			зохион байгуулсан сургалтын тоо-2 Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо- 200			авлигын эсрэг хууль, журмууд ТАЗ-н зөвлөмж, сурталчилгааны зурагт хуудас нарыг тогтмол шинэчилж байна. 2022 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Авлигатай тэмцэх газраас явуулсан "Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье" иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх хөтөлбөрт байгууллагын албан хаагчид бүрэн хамрагдсан. Хэрэгжилт 90 хувь
ТАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
Ногоон хөгжил						
5.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.						
22	"Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	-	Жорлонгийн тоо- 30	2021	70	2022 онд хагас жилийн байдлаар БОАЖГ, Сүмбэр сумын ЗДТГ-тай хамтран "Аюулгүй жишиг гудамж"-ны айл өрхүүд болон 2 дугаар багийн иргэдэд нээлттэй хаалганы өдөрлөгөөр стандарт шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн танилцуулга сурталчилах ажлыг хамтран зохион байгуулж нийт 70 гаруй айлд гарын авлага тарааж мэдээлэл өгсөн. 2.Сүмбэр сумын 3-р багт авто зам дагуу байрлах үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудад нүхэн жорлонг стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар шинэчлэн солих хугацаатай албан шаардлагыг 2022.06.03-ны өдрийн 01/178 албан тоотой 3 аж ахуйн нэгжид биелэлтийг III улиралд ирүүлэхээр хүргүүлсэн. Мөн орон нутгийн "Илчит-Сансар" ХХК сайжруулсан жорлонгийн кольцоог үйлдвэрлэж нийт 39 айл өрхөд нийлүүлэлт хийсэн байна. Хэрэгжилт 90 хувь
ЗУРГАА. БУС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
Орон нутаг, хөдөөгийн хөгжил						
6.1. Аймаг, сумдын төвийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.						
23	Аймаг сумдын төвийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчилнэ.	675.0	Бохирын шугаманд холбох ажлын гүйцэтгэл хувь-100	2021	30	БХБЯ захиалгатай Сүмбэр сумын 1-р багийн айл өрхийн бохир усыг төлөвлөрсөн бохир усны шугамд холбох ажлыг "Мөнхзүмбэр" ХХК 700,0 сая төгрөгийн өртгөөр хийж гүйцэтгэж байна. 2022 оны ажлын гүйцэтгэл 100 хийгдсэн. Дээрх инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэнээр 70 ААН, 408 айл өрхийн бохир усыг татан зайлуулах боломжтой болно. Хэрэгжилт 100 хувь
24	Айл өрхийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбоно.	-	Шинээр цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд холбогдсон өрхийн тоо - 10 Шинээр цэвэр усны шугамд холбогдсон гэр хорооллын айл өрхийн тоо -10	2021	70	1.Сүмбэр сумын ЗДТГ-н захиалгаар Сүмбэр сумын 3-р багт шинэ суурьшлын бүсэд 400м цэвэр усны шугам 6ш огтолгоо авах худаг, ус түгээх ухаалаг худаг нэг ширхгийг хийлгэхээр "Стронг найс констракш"н ХХК-тай гэрээ байгуулж 100% гүйцэтгэн, байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн 2. Шивээговь сумын цэвэр усны төв магистраль шугамын өргөтөл шинэчлэлийн ажлыг "Стронг найс констракш" ХХК 185,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгөөд байна. 3.Шивээговь сумын нийтийн эзэмшлийн орон сууцны 6,7 байрны зоорийн давхарын дулаан, цэвэр ус, бохирын шугам сүлжээний засварын ажлыг "Такамаца" ХХК 153,0 сая төгрөгийн өртгөөр хийж гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Шугам сүлжээний шинэчлэлд 150 айл өрх хамрагдсан байна. 4.БХБЯ захиалгатай Сүмбэр сумын 1-р багийн айл өрхийн бохир усыг төлөвлөрсөн бохир усны шугамд холбох ажлыг "Мөнхзүмбэр" ХХК 700,0 сая төгрөгийн өртгөөр хийж гүйцэтгэж байна. 2022 оны ажлын гүйцэтгэл 100

					<p>хийгдсэн. Дээрх инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэнээр 70 ААН, 408 айл өрхийн бохир усыг татан зайлуулах боломжтой болно.</p> <p>5.Сүмбэр сумын 3-р баг, нийтийн эзэмшлийн орон сууцны 6-р байр зоорийн давхарын дулаан, цэвэр ус, бохирын шугам сүлжээний засварын ажлыг "Ус-Ду"ОНӨААТҮГ 103,0 сая төгрөгийн өртгөөр хийж гүйцэтгэн, улсын комисс ажиллуулах шатандаа байна. Шугам сүлжээний шинэчлэлд 79 айл өрх хамрагдсан байна.</p> <p>Ингэснээр иргэдийн амьдрах орчныг сайжруулж, орон сууцны нөхцлийг нэмэгдүүлсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100 хувь</p>	
25	Сумдын төвд "Жишиг гудамж" хэрэгжүүлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	-	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо-1	2021	-	<p>"Аюулгүй жишиг хороолол" төслийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний дагуу Баянбулагийн хороололд Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар, Дэлхийн Зөн Бор-Өндөр 1 Олон Улсын байгууллага, Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ний Говьсүмбэр салбар, Цагдаагийн хэлтэс, Байгаль орчин аялал жуучлалын газар, Боржигин чуулга, Говьсүмбэр телевиз, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ, Улаан загалмайн хороо, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын холбогдох албан хаагчид 2022.04.28-29-ний өдрүүдэд хамтран ажиллаж газар дээр нь нөхцөл байдалтай танилцан ажилласан.</p> <p>Төлөвлөлтөнд орж байгаа Баянбулаг 1-4 гудамжны одоогийн байгаа байдлыг харуулахаар нисэгчгүй нисдэг төхөөрөмж дроныг ашиглан 2022.05.13-ний өдөр хэмжилт зураглалыг авсан. Мөн тухайн хээрийн зураглал дээр боловсруулалт хийн төлөвлөлтийн гэр хорооллолын зураглалыг хийсэн.</p> <p>Төлөвлөлтөнд орж байгаа Сүмбэр сумын Баянбулаг 1-4 гудамжны 89 өрхийн судалгааг үндэслэн Үл хөдлөх хөрөнгийн шинэчлэгдсэн гэрчилгээг тус ажил хийгдсэний дараа Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран гэрчилгээг олгохоор ажиллаж байна.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <p style="text-align: right;">Хэрэгжилт 90 хувь</p>

26	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтыг сайжруулж, гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлнэ.	439.2 87.0	Сүмбэр сумын 2-р багт тохижилтын ажлыг хийнэ. Шинээр хийгдэх гэрэлтүүлгийн тоо-34 Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт-100 хувь	2021	30	Сүмбэр сумын ЗДТГ-ын захиалгаар 70,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сүмбэр сумын 3-р багт Баянбулагийн 1-10 хүртэлх эгнээний 100 ширхэг гэрэлтүүлгийн толгой угсрах ажлын гүйцэтгэгчээр "Од жи Од" ХХК шалгарч ажлыг 100% гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. - Сүмбэр сумын 2-р багийн Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил АЗДТГ захиалгатай "Хүслэн хийморь" ХХК хийж гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Тус тохижилтын ажилд хэсэгчилэн хийгдсэн 16 ширхэг гэрэлтүүлэг, 2900м2 явган зам, резин хавтан 254м2, бетон талбай 151 м2, дугуйн зам 1050м2 тус тус хийгдсэн. -Шивээговь сумын ЗДТГ-ын захиалгаар 59,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр сумын гудамж тайлбайд гэрэлтүүлэг нэмэх, гэрэлтүүлгийн чимэглэл хийх ажлын гүйцэтгэгчээр "Од жи Од"ХХК шалгарч ажлыг 100% гүйцэтгэн, байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх шатандаа байна. Тус тохижилтийн ажилд 30ш гэрэлтүүлэг хийгдсэн байна. Хэрэгжилт 100 хувь
----	--	---------------	---	------	----	---

БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

№	Арга хэмжээний тоо	Үүнээс:						Биелэлтийн хувь
		Хэрэгжих шатандаа						
		100%	90%	70%	50%	30%	0%	
11	26	13	12	1	-	-	-	94,2%

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР